Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН СУВИЛАГЧ, ТУСГАЙ МЭРГЭЖИЛТНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ЦЭРЭН-ОЧИР ОВОГТОЙ ХАНДАРМААГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Сувилагч, тусгай мэргэжилтний бодлогын дүн шинжилгээ, урт дунд, богино хугацааны хэрэгцээний төлөвлөлт хийх” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** Сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтний хүний нөөцийн хэрэгцээний судалгаа хийж, хүний нөөц бэлтгэх тэргүүлэх чиглэл тогтоох | Тэргүүлэх чиглэл, холбогдох байгууллагад хүргүүлсэн баримт | 0 | Сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтний хүний нөөцийн хэрэгцээний судалгаа эхэлсэн байна. | Хүүхдийн сувилагч, нярайн сувилагч, нийгмийн эрүүл мэндийн сувилагч, хоол зүйч, уламжлалт анагаах ухааны сувилагчийн хүний нөөцийн хэрэгцээний судалгааг АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль, Сувилахуйн сургууль, Уламжлалт анагаах ухааны хүрээлэнгийн төлөөлөл, эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн нартай хамтран хийж байна. | 01-06 сар | 100 |
| 2. | **Арга хэмжээ 1.2** Нийгмийн эрүүл мэндийн сувилагч бэлтгэх, ажиллах эрх зүйн орчин бүрдүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх | Батлагдсан төлөвлөгөө, хэрэгжилт, хувиар | 0 | Төлөвлөгөөг батлуулах, үйл ажиллагааны 30 хувийг хэрэгжүүлсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/446 дугаар тушаалаар батлагдсан Нийгмийн эрүүл мэндийн сувилагч бэлтгэх асуудлаар холбогдох эрх зүйн баримт бичиг боловсруулах ажлын хэсгийн хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг Ажлын хэсгийн ахлагчаар батлуулсан.<br>Ажлын хэсгийн хурлын 2024 оны 11 дүгээр сарын 19, 2025 оны 01 дүгээр сарын 15, 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр тус тус хуралдаж, хийж байгаа ажлын явцын талаар мэдээлэл солилцож, асуудлыг шийдвэрлэн хамтран ажилласан.<br>Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/86 дугаар тушаалаар батлагдсан “Хүн амын эрүүл мэндийг дэмжих, амьдралын зөв дадал хэвшилтэй иргэнийг | 01-06 сар | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | бий болгох "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөний 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө-ний 1.8-д "Нийгмийн эрүүл мэндийн сувилахуйн бакалаврын сургалтын хөтөлбөр, цогц чадамж, хөтөлбөрийн индекс, ажлын байрны тодорхойлолт боловсруулж батлуулах" ара хэмжээг тусган, 70,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлээд байна.<br>Нийгмийн эрүүл мэндийн сувилагч бэлтгэх нийгмийн болон суралцагч, ажил олгогчийн хэрэгцээг тодорхойлох судалгааны арга аргачлалыг хэлэлцүүлж батлуулан, 2025 оны 2 дугаар сараас эхлүүлж, одоогоор 500 хүнээс судалгаа аваад байна. Тус судалгаагаар Нийгмийн эрүүл мэндийн сувилагч ажиллах эрхзүйн баримт бичиг болон ажиллах хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлага тодорхойлогдох юм.<br>Нийгмийн эрүүл мэндийн сувилагчийн албан тушаалын тодорхойлолтын төсөл (5 хуудас)-ийг боловсруулсан.<br>Япон улсын Тоото их сургуулийн НЭМУ-ы доктор НЭМ-ийн сувилагч багш Шёото Огава тус ажлын хэсгийн гишүүдэд "Нийгмийн эрүүл мэндийн сувилагчийн ажил үүрэг, Япон улсын туршлага" сэдвээр илтгэл хэлэлцүүлж, туршлага солилцлоо.<br><br>АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн 1 дүгээр дамжааны 271 оюутанг оролцуулан Япон улсын "Нийгмийн эрүүл мэндийн сувилахуй" хичээлийн хөтөлбөр, Нийгмийн эрүүл мэндийн сувилагчийн талаар мэдээлэл танилцуулж, ойлголт, мэдлэгийг нэмэгдүүллээ.<br>2025 оны 4 сарын 18 ны өдөр Нийгмийн эрүүл мэндийн сувилагчийн хэрэгцээ шаардлагын асуудлаар талаар Монгол Улсын хэмжээнд Сувилахуйн хөтөлбөр хэрэгжүүлэгч 16 их дээд | | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | сургуулийн багш нарын төлөөлөл оролцуулан танилцуулж, санал солилцсон.<br>Нийгмийн эрүүл мэндийн сувилагчийг бэлтгэх сургалт, хөрвөн суралцах, шаталсан сургалтын асуудлыг судлан шийдвэрлэх арга хэмжээний хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр 12 кр сургалтын төлөвлөгөөг АШУҮИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцүүлж батлуулсан. Үүнд: 4 дүгээр дамжааны сүүлийн 1 жилд, шаталсан бакалавр 1 жилээр, ТДС-ын 3 сарын сургалтын хөтөлбөрийг тус тус батлуулсан. | | |
| 3. | **Арга хэмжээ 1.3**<br>ЗГҮАХ 2.3.4.2<br>Сувилагч, туслах сувилагчдыг бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлэх | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br>Бэлтгэгдсэн сувилагч, туслах сувилагч, өссөн тоогоор | 2024 онд 580 сувилагч, туслах сувилагч | БЯ, АШУҮИС-ийн Сувилахуйн сургуультай уулзалт, хэлэлцүүлэг хийж, шаардлагатай эрхзүйн зохицуулалтыг хийнэ. | Сувилагч, туслах сувилагчдыг бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд АШУҮИС-ийн Сувилахуйн сургуультай хамтран Сувилахуйн сургалт, судалгааны төвийн нээлтийг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан.<br>Архангай аймаг дахь "АШУҮИС-ийн Сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эмнэлгийн тусламж, үйлчилгээний цогцолбор"-ын Сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хийж байна. "Сувилахуйн багш нарыг бэлтгэх чадавхжуулах" хөтөлбөр боловсруулж, сургалтыг зохион байгуулсан. Ингэснээр орон нутагт сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэнг бэлтгэх, мэргэшүүлэх замаар хүний нөөцөөр хангах боломж бүрдэнэ.<br>Шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх талаар БЯ, АШУҮИС-ийн Сувилахуйн сургуультай хамтран ажиллаж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Мэргэжлийн чиглэл /хөтөлбөлбөрийн нэр/ индекс" шинэчлэн батлах тухай" А/146 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх | 01-06 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | “Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/ индексийн жагсаалт“-д 09503-Хэл засал, 098802-нийгмийн эрүүл мэндийн сувилахуйн индекс, хөтөлбөрийг нэмж тусган Боловсролын сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/287 дугаар тушаалаар батлуулсан. | | |
| **Зорилт 2. “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн нийгмийн баталгааны бодлого, хэрэгжилтийн нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалтаар хангах” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 4. | **Арга хэмжээ 2.1** Орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах боломж нөхцөлийг судалж, хамрах хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр банкуудтай хамтран ажиллах | Орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдсан эмнэлгийн ажилтны тоо, өссөн дүнгээр | Голомт банк-132 ХХБ-372 эмнэлгийн ажилтан | Банкуудтай байгуулсан санамж бичгийн хэрэгжилтийг дүгнэн, хамрагдалтыг нэмэгдүүлэх уулзалт хэлэлцүүлэг хийнэ | Эрүүл мэндийн яам Худалдаа хөгжлийн банктай 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг 2 жилийн хугацаатай, Голомт банктай 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр “Хамтран ажиллах тухай санамж бичиг”-ийг Нэг жилийн хугацаатай тус тус байгуулсан байна.<br>2024 онд ипотекийн зээлд хамрагдсан байлыг дүгнэхэд,<br>2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр 4/195 тоот албан бичгээр Голомт банк, Худалдаа хөгжлийн банкнаас хэрэгжилтийн мэдээллийг авсан. Үүнд:<br>Худалдаа, хөгжлийн банкны зүгээс 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор нийт 7328 харилцагчдад, 140.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгосон байна.<br>Голомт банкнаас ирүүлсэн 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 16/0358 тоот албан бичигт:<br>1. Голомт банкаар дамжуулан цалингаа авсан харилцагчийн тоо -3,458<br>2. Голомт банканд цалингийн зээлтэй харилцагчийн тоо – 2570 | 01-06 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | 3. Цалингийн зээлийн багцын дүн – 33,3 тэрбум<br>4. Орон сууцны зээлтэй харилцагчийн тоо- 132<br>5. Орон сууцны зээлийн багцын дүн -11,9 тэрбум<br>6. Эмч карттай харилцагчийн тоо - 168<br>Нийтдээ эрүүл мэндийн салбарын 1233 ажилтан ипотекийн зээлд хамрагджээ. Үүнээс эмч-455, сувилагч-407, эмнэлгийн бусад мэргэжилтэн – 390 байна.<br>2024 оны Ипотекийн зээл олгосон банкуудын мэдээллээс харахад,<br>Хаан банк хамгийн их буюу 408, Голомт банк -191, ХХБ -272, бусад банк- 352 ажилтанг ипотекийн зээлд хамруулжээ. Ипотекийн 3 хувийн зээлд 30 ажилтан хамрагдсанаас хаан банкнаас 7, бусад банкнаас 23 байна. 6 хувийн зээлийг Худалдаа хөгжлийн банк хамгийн их олгосон бөгөөд нийт 238 ажилтанд олгожээ.<br>2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Голомт банкны төлөөлөлтэй уулзаж, санамж бичгийн хэрэгжилт, санамж бичгийг сунгахгүйгээр уулзалтаар ярьж тохирсон шинэ заалтуудаа нэмж, шинэчлэн байгуулахаар ажиллаж байна. | | |
| 5. | **Арга хэмжээ 2.2.** Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах шийдвэр | 0 | Нөхцөл байдлыг судлан, төсөл боловсруулна. | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн нийгмийн баталгаа, ажлын ачаалал, цалин хөлс, хөдөлмөрийн норм норматив, хөдөлмөрийн нөхцөл байдлыг судлан, төсөл (12 хуудас) боловсруулсан. | 01-06 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 6. | **Арга хэмжээ 2.3.** Шинэ сувилагч, эх баригчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Шинэ сувилагч, эх баригчийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байгууллагын тоо -6 | 2024 онд ЭХЭМҮТ - шинэ эх баригч, УХТЭ, Орхон аймгийн БОЭТ - шинэ сувилагч-2 | Шинэ эх баригч -1<br>Шинэ сувилагч -2 байгууллага | Шинэ сувилагч, шинэ эх баригчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын удирдамжийг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Удирдамжийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтрагч байгууллагуудад 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 4/2697 тоот албан бичгийг хүргүүлсэн.<br>2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Загвар байгууллагуудад хэрэгжүүлсэн шинэ сувилагч, эх баригчийн хөтөлбөрийн үр дүн, анхаарах асуудлуудын талаар хэлэлцэн, цаашид хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаанд тусгах зорилгоор уулзалтыг хийлээ. Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв, СХД-ийн Нэгдсэн эмнэлэг, Булган, Төв аймгийн Нэгдсэн эмнэлэгт шинэ сувилагчийн хөтөлбөрийг, Нийслэлийн Хүрээ амаржих газар, Өргөө амаржих газарт шинэ эх баригчийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс УНТЭ, СХД-ийн Нэгдсэн эмнэлэгт шинэ сувилагчийн хөтөлбөр, Өргөө амаржих газарт шинэ эх баригчийн хөтөлбөрийг эхлүүлж, чиглүүлэгч нарыг томилон ажиллуулж байна. | 01-06 | 100 |
| 7. | Арга хэмжээ 2.4.<br>Эрүүл мэндийн ажилтны гүйцэтгэлийн жишиг шалгуур үзүүлэлт боловсруулах | Батлагдсан жишиг шалгуур үзүүлэлт | 0 | Эрүүл мэндийн ажилтны гүйцэтгэлийн жишиг шалгуур үзүүлэлт боловсруулах ажлын хэсэг байгуулж, төслийг боловсруулна. | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт болон үйл ажиллагааны гүйцэтгэлийг дүгнэх журам боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг боловсруулж, хэлтсийн даргаар хянуулан, газрын даргад танилцуулсан.<br>Газрын дарга өмнө тойрч байсан ЭМС, ГБХНХС, СС--ын хамтарсан тушаалаар батлагдах “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам”, “Эрүүл мэндийн салбарын төрийн | 01-06 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур"-ын төслийг судлан, яамны удирдлагуудас санал авч батлуул гэсэн чиглэлийн дагуу санал авч байна. | | |
| Зорилт 3. "Салбарын хүний нөөцийн нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохицуулах" зорилтын хүрээнд | | | | | | | |
| 8. | Арга хэмжээ 3.1.<br><br>Салбарын хүний нөөцийн нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар судлах, санал боловсруулах | Боловсруулсан санал, тоогоор | 0 | Салбарын хүний нөөцийн нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар судалж, дүгнэнэ. | Эмнэлгийн мэргэжилтний тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байна. Нийгмийн баталгааны чиглэлээрх үндэслэл, мэдээлэл бэлтгэж өгсөн. Хуульд тусгах заалтуудыг боловсруулж хэлэлцүүлсэн.<br>- ХХОАТ, Нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах<br>- Өдөр өнжүүлэх, хүүхдийн цэцэрлэг (24цагийн) байгуулах<br>- 15-аас доошгүй жил эрүүл мэндийн салбарт тасралтгүй ажилласан албан хаагчийн нэг хүүхдийг их, дээд сургуульд суралцах төлбөрийг төр даах<br>- Орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх<br>- Ажлын дарамт, шахалтаас урьдчилан сэргийлэх, үүссэн тохиолдолд авах арга хэмжээний зохицуулалтыг тусгах<br>- Ажиллах боломжоор хангах /хувцас хэрэгсэл, ажиллах орчин, хөдөлмөрийн авцлгүй байдал, бие махбодийн болон сэтгэл зүйн таатай орчин гэ мэт/<br>- Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дэх заалтуудыг дэлгэрэнгүй тодорхой томъёолох гэх мэт<br>- Нийгмийн баталгааны нөхцөлийг тусгай албан хаагчийн баталгаатай дүйцүүлэн тусгах | 01-06 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 9. | Арга хэмжээ 3.2.<br><br>Эрүүл мэндийн ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, хяналтанд авах, эмчлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авах | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эрүүл мэндийн ажилтан, тоогоор | 0 | Эрүүл мэндийн байгууллагуудад чиглэл хүргүүлнэ. | Эрүүл мэндийн ажилтнуудтай хийсэн уулзалтаас гарсан санал, хүсэлтийг үндэслэн Эрүүл мэндийн ажилтны эрүүл мэндийг хамгаалах, дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх, улмаар өвчний учир эмнэлэгт хандсан тохиолдолд чирэгдэлгүй, хүндэтгэлтэй хандаж, тусламж, үйлчилгээ авах боломж, нөхцөлөөр хангах талаар бүх шатны өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт хүргүүлэх 9 заалт бүхий чиглэлийг боловсруулж, удирдлагуудад танилцуулсан. ЭМЯ-ны 2025 оны төлөвлөгөөний 31-д Ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах журмыг 3-4 дүгээр улиралд батлуулна гэж тусгасан тул нэгдсэн нэг зохицуулалт гаргахаар хойшлогдоод байна. | 01-06 | 80 |
| 10. | Арга хэмжээ 3.3.<br><br>Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын ачаалал тооцох, хөдөлмөрийн норм, норматив тогтоох аргачлалыг шинэчлэн боловсруулж, батлуулах | Хамтарсан тушаал | ХНХС, ЭМС-ын 2019 оны 5 сарын 30-ны А/185/А/252 дугаар хамтарсан тушаал | Аргачлалыг шинэчлэх ажлын хэсэг байгуулж үнэлгээг эхэлсэн байна. | Аргачлалыг шинэчлэх ажлын хэсэг байгуулахаар ГБХНХЯ-д ажлын хэсэгт ажиллах албан тушаалтныг ирүүлэх тухай албан тоотыг боловсруулсан болович Газрын дарга шаардлагагүй гэсэн тул түр хойшлогдсон. | 01-06 | 50 |
| **Зорилт 4. “Гурван талт хамтын хэлэлцээр байгуулах, дүгнэх үйл ажиллагааны зохицуулалт, тайлагналт” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 11. | Арга хэмжээ 4.1.<br><br>Эрүүл мэндийн салбарын 2025- | 2025 оны арга хэмжээний хэрэгжилт 100 хувь | 0 | Батлагдсан төлөвлөгөө | - Эрүүл мэндийн салбарын 2025-2026 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө (7 зорилтын хүрээнд нийт 78 арга хэмжээ)-г боловсруулж, яамны газар, | | 80 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | 2026 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж батлуулах | | | | хэлтсийн даргад танилцуулан, Монголын Хувийн Хэвшлийн Эрүүл Мэндийн Байгууллагын Нэгдсэн Холбоогоор батлуулан, Монголын Эрүүл Мэндийн Ажилтны Үйлдвэрчний Эвлэлийн Холбоонд хүргүүлсэн боловч 2025 оны 4 сард нэмэлт хэлэлцээр хийх гэж байгаа тул түр хойшлуулах санал ирсний дагуу батлагдаагүй.<br>- Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооноос 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 1/88 тоот албан бичгээр нэмэлт хэлэлцээр байгуулах тухай санал ирсэн. Саналын дагуу Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/184 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн салбарын хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2024-2026 оны гурван талт хамт (тариф)-ын хэлэлцээрийн биелэлтийг дүгнэх, 2025 оны нэмэлт хэлэлцээр байгуулах ажлын хэсэг байгуулагдсан.<br>- Ажлын хэсгийг хуралдуулахаар төлөвлөж байна. | | |
| 12. | Арга хэмжээ 4.2.<br><br>Гурван талт хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг тайлан гаргах, дүгнэх | Тайлан, дүгнэлт гарсан байна. | 2022-2023 оны хамтын хэлэлцээрийн тайлан | Хагас жилийн тайлан | - Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/184 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн салбарын хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2024-2026 оны гурван талт хамт (тариф)-ын хэлэлцээрийн биелэлтийг дүгнэх, 2025 оны нэмэлт хэлэлцээр байгуулах ажлын хэсэг байгуулагдсан. | | 80 |
| 13. | Арга хэмжээ 4.3. Хөдөлмөрийн тухай хууль болон хамтын гэрээ, | 8 байгууллагын үйл ажиллагаанд | 0 | 4 эрүүл мэндийн байгууллага | - Хөдөлмөрийн тухай хууль болон хамтын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилт, хөдөлмөрийн харилцааны чиглэлээр эрүүл | | 80 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | хэлэлцээрийн хэрэгжилт, хөдөлмөрийн харилцааны чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх | хамтарсан үзлэг, хяналт хийсэн байна. | | | мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх удирдамжийг Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран боловсруулж, санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Тус удирдамжид Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, Арьсны өвчин судлалын үндэсний төв, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг, Төв аймгийн Сүмбэр сумын эрүүл мэндийн төв, СБД -ийн өрхийн эрүүл мэндийн төв, БЗД-ийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэгт хяналт хийнэ.<br>- Монголын эрүүл мэндийн ажилтны анхан шатны Үйлдвэрчний эвлэлийн хороодын дарга, идэвхтэн сонгуультны 5 дугаар зөвлөгөөнд 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр оролцож, асуултад хариулж, санал, хүсэлтийг сонслоо. | | |
| **Зорилт 5. “Сувилагч, тусгай мэргэжилтний хөгжил, нийгмийн баталгааны чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалтаар хангах” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 14. | Арга хэмжээ 5.1. Боловсролын яамтай Хамтын ажиллагааны гэрээ байгуулах | Баталгаажсан хамтын ажиллагааны гэрээ | 0 | Төслийг боловсруулж, хэлэлцүүлсэн байна. | Эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх төгсөлтийн өмнөх сургалтын тогтолцоог сайжруулах чиглэлээр Боловсролын яамны Дээд боловсролын газар, анагаах ухааны боловсрол олгодог улсын болон хувийн хэвшлийн их, дээд сургуулийн удирдлагуудтай 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн мөрөөр 13 заалт бүхий хамтын ажиллагааны гэрээний төслийг боловсруулж, батлуулахад бэлэн болсон.<br>-2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 1а/1854 тоот албан бичгээр Эрүүл мэндийн салбарын хүний | | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | нөөцийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, технологийн хурдацтай хөгжил, салбарын ажиллах хүчний эрэлт, хэрэгцээ, өвчлөлийн төлөв байдалд нийцүүлэн дээд боловсролын тэргүүлэх чиглэл болон эрэлттэй мэргэжлийн чиглэлд нэмж тусгах санал,<br>-2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 2/2598 тоот албан бичгээр Эрүүл мэндийн эдийн засагч, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн мэргэжилтэн, Эрүүл ахуй, Тархвар судлалын мэргэжилтний төгсөлтийн өмнөх сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай,<br>-2025 оны 06 дугаар сарны 02-ны өдрийн 2/2914 тоот албан бичгээр "Нийгмийн эрүүл мэнд судлаач", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн", "Эрүүл ахуйч, тархвар судлаач", "Эрүүл мэндийн хоол зүйч", "Эдийн засагч", "Нийгмийн ажилтан" мэргэжлээр орон нутгийн хэрэгцээнд үндэслэн дээрх мэргэжлээр хүний нөөцөө сургахад анхаарч, АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуультай хамтран ажиллах тухай хүргүүлж хамтран ажилласан. | | |
| 15. | Арга хэмжээ 5.2. Сувилагч мэргэжилтний хөгжил чадварын түвшин, түүнийг тогтоох жишиг аргачлал, загварыг батлуулах | Батлагдсан тушаал | 0 | Туршсан тайланг хэлэлцүүлсэн байна. | "Сувилагч мэргэжилтний хөгжил, чадварын түвшин, түүнийг тодорхойлох жишиг аргачлал, үнэлгээний жишиг загвар"-ын төслийг туршсан тайланг 5 дугаар сард багтаан хэлэлцүүлэх тухай 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 4/2625 тоот албан бичгийг ЭМХТ-д хүргүүлж, чиглэл өгч ажиллаж байна. | | 50 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Үүрэг даалгавар (арга хэмжээ)1. 1 Олон улсын сувилагчдын өдрийг тэмдэглэх | Авсан арга хэмжээний тайлан | 1 | 1 | - Сувилагчаа сонсъё арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 05 дугаар сарын 09-ний өдрүүдэд зохион байгуулах бэлтгэл ажлыг хийсэн. Үүнд: 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 3/1983 тоот албан бичгээр оролцогчдыг мэдээллийг авч, оролцогчдын хуваарийг байгууллага, өдөр тус бүрээр гаргасан. Мөн аз хур, тогтуун фүүдланд ХХК-уудтай гэрээ байгуулахаар хамтран ажилласан.<br>- Эрүүл мэндийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан сувилагч нарт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах А/139 дүгээр тушаалыг батлуулсан. Тус арга хэмжээг Ерөнхийлөгчийн ивээл дор энэ оны 05 дугаар сарын 12-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Эрүүл мэндийн байгууллагын 900 гаруй төлөөлөл оролцлоо.<br>- Төрийн нарийн бичгийн даргаар Сувилагч тандаа баярлалаа-2025 зөвлөгөөнийг зохион байгуулах нарийвчилсан төлөвлөгөө, ажиллах удирдамж, санхүүжилттийг батлуулсан.<br>- Эрүүл мэндийн сайдаар Сувилагч тандаа баярлалаа-2025 зөвлөгөөний хөтөлбөрийг батлуулсан.<br>- Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын үгийн төслийг бэлтгэсэн.<br>- Сувилагч тандаа баярлалаа-2025 зөвлөгөөний тараах материалыг сонгох, бэлтгэх 49, 50, 51 дүгээр хамтран ажиллах гэрээ, арга хэмжээг зохион байгуулах 48 дугаар гэрээг тус тус боловсруулж батлуулсан. | | 100 |
| 2 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.2. Газрын даргын өгсөн үүргийн дагуу | Авсан арга хэмжээний тайлан | 0 | 1 | - 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрөөс 02 дугаар сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж байгаа орон нутгийн хяналт шалгалтын бүрэлдхүүнд оролцож, Булган аймгийн төв болон Рашаант, Гурванбулаг, Дашинчилэн, Баяннуур сум, Хөвсгөл аймгийн төв, Түнэл, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Ханх, Алаг-Эрдэнэ сумын төвд ажиллалаа. Хөвсгөл, Булган аймгийн суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн | | 100 |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | байгууллагууд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж буй байдал, хүний нөөцийн зохицуулалтын хэрэгжилттэй танилцан хяналт шалгалт хийж, албан хаагчидад төрийн албаны шинэчилэлтийн талаар мэдээлэл, сургалт зохион байгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн тусласан.<br>- Эрүүл мэндийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/38 дугаар тушаалаар батлагдсан Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн Хөтөлбөр зохицуулах нэгжид ажиллах ДОХ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн сонгон шалгаруулах "Ажлын хэсэг"-т 4 сарын 28-наас 5 сарын 28-ны өдрүүдэд удирдамжийн дагуу ажиллаж дуусгасан.<br>- Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 сарын 13-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар байгуулагдсан Аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв болон эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн нэгж, албаны бүтэц, дүрмийг боловсруулах техникийн ажлын хэсгийн хуралд 3 сараас 6 сар хүртэл үүрэг чиглэл авч ажиллаж байна. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Албан тушаалын онцлогоос хамаарсан гадаад хэл болон салбарын хууль | Сургалтад бүрэн хамрагдаж, багц цагийг биелүүлэх | 1 | 1 | Talk talk English сургалтад 2025 оны 01 дүгээр сараас 9-12 дугаар шатлалыг дүүргэн, 2025 оны 4 сарын 17-ны өдөр төгссөн. | 01-06 сар | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | тогтоомжид заасан зайлшгүй шаардлагатай ур чадварыг мэргэжлийн байгууллагаар дамжуулж суралцаж эзэмших | эсхүл шалгалт өгч гэрчилгээ авах | | | | | |
| 2. | **Арга хэмжээ 2.** Албан тушаал, чиг үүрэгтэй холбоотой сургалтыг мэргэжлийн байгууллагаар дамжуулж суралцаж эзэмших | Сургалтад бүрэн хамрагдаж, багц цагийг биелүүлэх эсхүл шалгалт өгч гэрчилгээ авах | 0 | 1 | 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Олон улсын Улаанбаатар их сургуулийн 30 жилийн ойн баярт зориулсан “Тогтвортой хөгжилд сувилагчийн оролцоо” олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцож, албан тушаал, чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл авч, ойлголт нэмэгдсэн.<br>2025 оны 06 сарын 26-28-ны өдөр “Донороос цусны үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээ” олон улсын симпозиумд оролцохоор бүртгүүлээд байна. | 01-06 сар | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Сувилагч, эмнэлгийн мэргэжилтний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн ........................ / ........................ / 2025 оны 06 дугаар сарын

*(Албан тушаал)* *(Нэр, гарын үсэг)* *(Огноо)*